



## НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

### Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/199 дүгээр захирамж, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/199 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 2, 3 дугаарт заасан ажлуудыг Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд тусгагдсан, материалын үнийн өөрчлөлтийн зөрүү тооцсон нэмэлт гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, шийдвэрийг мөрдөн ажиллаж, үр дүнг тайлагнахыг Үнэлгээний хорооны дарга (С.Баасансүрэн)-д даалгасугай.


3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (С.Цэдэнсодном)-т даалгасугай.

4.Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Х.Энхбаясгалан)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.МӨНХБАТ

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын  
даргын 2023 оны 04 дүгээр сарын 04-ний  
өдрийн А/28 дугаар тушаалын хавсралт



## ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:

С.БААСАНСҮРЭН  
(НХОГ-ын Бүсийн Ахлах инженер)

ГИШҮҮД:

Г.ТЭМҮҮЖИН

(НЗДТГ-ын Хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн Эрчим  
хүчний бодлого төлөвлөлт  
хариуцсан мэргэжилтэн)

Д.ПҮРЭВЖАВ

(НХОГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн  
Хөрөнгө оруулалтын санхүүжилт  
хариуцсан Ахлах мэргэжилтэн)

Ц.БЯМБАЖАВ

(Баянгол дүүргийн 5 дугаар  
хорооны иргэн)

НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА:

Х.ЭНХБАЯСГАЛАН

(НХОГ-ын Зураг төслийн  
хэлтсийн  
Зураг төслийн хяналтын инженер)